



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 18

Дугаар 04

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.6 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

2. Ногдол ашиг хуваарилаагүй тухай шийдвэр, түүний тайлбарын талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлбарлахыг ТУЗ-ийн аудитын хорооны дарга Д.Эрдэнэцэцэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Г.АЮУШМАА



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 18

Дугаар 06

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ


Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоол, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 10:30 цагт тус компанийн хурлын танхимд хуралдуулсугай.
2. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, батлах
 - 2.2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
 - 2.3. Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
 - 2.4. ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны төсөв, гишүүдийн урамшууллын хэмжээг батлах
 - 2.5. Ногдол ашгийн хуваарилалтын талаар тайлбар сонсох зэрэг болно.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
4. Ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, 2019 оны 2 дугаар сарын 21, 3 дугаар сарын 08-ны өдрүүдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр, компанийн цахим хуудас болон Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус тус дамжуулан хувьцаа эзэмшигчдэд болон нийтэд мэдээллэх, брокер дилерийн компаниудад ээлжит хурлын зарыг цахимаар хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуунд даалгасугай.
5. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загварыг Хавсралт №01-ээр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №02-оор, саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчийн санал авах хуудасны агуулгыг Хавсралт №03-аар тус тус баталсугай.

6. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээлэл, баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөр тогтоосугай.
7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 18:00 цагаар тогтоосугай.
8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах, зохион байгуулах комиссын даргаар Г.Аюушмаа, комиссын гишүүдэд ТУЗ-ийн гишүүн Д.Оюун, Ч.Энхтуул нарыг тус тус томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар Т.Байгаль /РД: ТА91122321/, гишүүдэд Н.Түмэндэмбэрэл /РД: ЛЮ91040408/, Т.Чойжамц /РД: ЙЕ93031114/ нарыг тус тус томилсугай.
10. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногийн дотор буюу 2019 оны 2 дугаар сарын 21-ний дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид Монголын хөрөнгийн биржийн сайтад бүртгэгдсэн и-мэйл хаягаар хүргүүлсүгэй.
11. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.АЮУШМАА

